



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/73

Сүхбаатар сум

Аян зохион байгуулах тухай


Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39.1 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлигаар батлагдсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 3 дугаар бүлгийн 1 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.10, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.10.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хил хамгаалах албыг бэхжүүлэх, хил хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Нэг мянгат-Нэг агт” аяныг иргэд аж ахуйн нэгж, байгууллага олон нийтийн санал санаачлагад тулгуурлан зохион байгуулахыг сум, багийн Засаг дарга нарт даалгасугай.

2.Аян зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалт, хяналтаар хангаж дүнг нэгтгэн жил бүрийн 04 дүгээр сарын 20-ны дотор танилцуулахыг аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д үүрэг бслгосугай.

3.Эх срныхоо хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хил хамгаалах үйлсэд туслах энэхүү аянд идэвх, санаачлагатай оролцохыг аймгийн нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад уриалсугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ